



**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2022 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/76

Улаанбаатар хот

**Дотоод аудит зохион байгуулах тухай**

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоол, Чанарын менежментийн тогтолцоо, стандартын шаардлага /MNS ISO 9001:2016/ үндэсний стандарт, Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо /MNS OHSAS 18001:2012/ үндэсний стандарт, Үндэсний төвийн Ерөнхий захирлын 2022 оны А/03 дугаар тушаал, “Дотоод аудит зохион байгуулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төвийн орон тооны бус алба, баг, зөвлөл, комиссын 2022 оны тайлан, Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэрийн хэрэгжилтэд дотоод аудит хийх багийн бүрэлдэхүүнийг 1, Дотоод аудит хийх төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дотоод аудит хийхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг ханган, хамтран ажиллахыг орон тооны бус алба, баг, зөвлөл, комиссын дарга нарт үүрэг болгосугай.

3. Дотоод аудитын үнэлгээний дүн, тайланг Удирдлагын зөвлөлд танилцуулан зохих арга хэмжээ авч ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч /Э.Тунгалагтуяа/-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөц, хуулийн зөвлөх /Я.Тогтохням/-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  Н.ЭРДЭНЭБАЯР



080410

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын  
2022 оны .... сарын ... өдрийн  
..... дугаар тушаалын  
1 дүгээр хавсралт

1118266548 9128905


**Дотоод аудит хийх багийн бүрэлдэхүүн**

Ахлагч: Э.Тунгалагтуяа –Захиргаа, маркетингийн албаны  
Дотоод аудитор

Гишүүд: Б.Солонго -Эрдэм шинжилгээ, мэдээллийн  
технологийн албаны дарга

Ч.Батболд- Захиргаа маркетингийн албаны дарга

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын  
2022 оны ..... сарын .... өдрийн  
..... дугаар тушаалын  
2 дугаар хавсралт



### Дотоод аудит хийх төлөвлөгөө

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Үр дүн
1	Аудит хийх мэдээллийг хүргүүлнэ	11 сарын 10	Э.Тунгалагтуяа	Аудит хийх мэдээллийг ажиллагсад хүлээн авч, бэлэн байдлыг хангана
2	Аудитын багийн ахлагч, гишүүдийг сонгож үндэсний төвийн захирлын тушаал гаргах	11 сарын 15	Э.Тунгалагтуяа	Аудитын баг бүрдэнэ.
3	Аудитын багийн ахлагч, гишүүдэд аудит явуулах чиглэл өгөх	11 сарын 15	Э.Тунгалагтуяа	Аудитын үйл ажиллагаа журмын дагуу зохион байгуулагдана.
4	Аудит хийх тайлангийн загвартай танилцах	11 сарын 15	Багийн гишүүд	Аудит хийх, үнэлэх үйл ажиллагаа тодорхой болно
5	Аудитыг зохион байгуулах	11 сарын 15 12 сарын 09	Багийн гишүүд	
6	Аудитын тайлан бичих	12 сарын 12	Багийн гишүүд	Тайлан, зөвлөмж хүргүүлэх, үл тохирол илрүүлсэн бол залруулах хугацаа өгөх.
7	Хаалтын хурал	12 сарын 12	Аудитын багийн гишүүд	
8	Үл тохирлыг хаалгах	12 сарын 20	Хариуцсан нэгж	Үйл ажиллагаа сайжирна.